



## ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар А/09

Улаанбаатар хот

### Биеийн тамир, спорт хамтлаг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Биеийн тамир, спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.1, 13.1.2, 13.1.3, 13.1.4, Нийслэлийн Засаг Даргын 1649, Газрын дүрмийн 7.1.1 дэх заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Албан хаагчдын бие бялдрыг хөгжүүлэх, амьдралын зохистой хэвшлийг төлөвшүүлэх зорилгоор хамт олны дунд биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлтийн арга хэмжээг төлөвлөн зохион байгуулах, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохион байгуулагдах спортын арга хэмжээнд хамт олны оролцоо, идэвхийг нэмэгдүүлэн ажиллах үүрэг бүхий Биеийн тамир, спортын хамтлагийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Газрын хэмжээнд зохион байгуулах биеийн тамир спортын арга хэмжээний төлөвлөгөө гарган хэрэгжүүлэх, ажлын үр дүнг хагас жил тутам тайлагнаж ажиллахыг Биеийн тамир спортын хамтлаг (Б.Найрамдал)-д үүрэг болгосугай.

3. Биеийн тамир, спорт хамтлагийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс (Э.Даваахатан)-д даалгасугай.

4. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан “Биеийн тамир, спорт хамтлаг шинэчлэн байгуулах тухай” Газрын даргын 2022 оны 03 дугаар сарын 01-ний өдрийн А/12 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



С.ТӨМӨРДУЛАМ

1150500043

Газрын даргын 2023 оны ... дүгээр  
сарын ...-ны өдрийн ... дугаар  
тушаалын хавсралт



**БИЕИЙН ТАМИР, СПОРТ ХАМТЛАГИЙН  
БҮРЭЛДЭХҮҮН**

Зөвлөлийн ахлагч:

Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн дарга

Гишүүд:

Барилгын стандарт, аюулгүй байдлын хяналтын  
хэлтсийн улсын байцаагч

Дэд бүтцийн стандарт, хяналтын хэлтсийн  
улсын байцаагч

Байгаль орчны стандартын хэлтсийн  
мэргэжилтэн

Барилга байгууламжийн ашиглалт бүртгэлийн  
хэлтсийн мэргэжилтэн

Захиргаа, санхүүгийн хэлтсийн ажилтан

Худалдаа үйлчилгээний стандартын хэлтсийн  
мэргэжилтэн

Хотын хөгжлийн стандартын хэлтсийн  
мэргэжилтэн

Нарийн бичгийн дарга:

Хотын хөгжлийн стандартын хэлтсийн  
мэргэжилтэн